Rachel Carson

Рэйчель Карсон

Pen Against Poison

Хорыг Дийлсэн Үзэг

When a strange blight crept over the area and everything began to change. ... There was a strange stillness. ... The few birds seen anywhere were moribund; they trembled violently and could not fly. It was a spring without voices. On the mornings that had once throbbed with the dawn chorus of scores of bird voices there was now no sound; only silence lay over the fields and woods and marsh.

Rachel Carson, Silent Spring

Cover photo: Rachel Carson at her microscope, 1951. Above: Baby wrens call for their supper.

Хавтасны зургийг: Рэйчель Карсон микроскопоор дурандаж байна. 1951 он. Дээд талын зураг: Уран бялзуухайн ангаахайнууд оройн хоолоо нэхэж буй нь.

Эгтэл өмнө байгаагүй нэгэн тахал мэт хар юм хаа сайгүй чимээгүйхэн гэтэж тархахын хирээр бүх юм урьдын мөн чанараа алдаж хувьсаж эхлэв. ... Амьдрал зогссон мэт нэг л ер бусын чимээ аниргүй. ... Хаа нэгтээ харагдах ганц хоёр шувуу үхэл ирж явааг мэдэрсэн юм шиг бөмбөгөнөтөл чичирч жигүүрээ дэлгэн нисэж үл чадан бээрсэн бололтой. Үүрийн гэгээг шувуудын жиргээнээр тосон угтдаг байсан энэ газар энэ удаа дуу чимээгүй хавар ирж, тариалангийн талбай, ой мод, ус намаг эл хуль болж, чимээ анир нь тасрав.

Рэйчель Карсон, Чимээгүй Хавар

Table of Contents

A Quiet Woman Whose Book Spoke Loudly 1
By Phyllis McIntosh

A Book That Changed a Nation 8
By Michael Jay Friedman

A Persistent Controversy, a Still Valid Warning 14
By May Berenbaum

Rachel Carson's Legacy 20
A photo essay

Bibliography 23
Additional readings and Web pages

Гарчиг

Даруухан зохиолч эмэгтэйн даацтай бүтээлүүд 1
Филлис МэкИнтош

Америк оронд өөрчлөлт авчирсан ном 8
Майкл Жэй Фрийдмэн

Бэрх сорилтыг давж чадсан сэрэмжлүүлэг 14
Мэй Беренбаум

Рэйчель Карсоны хойч үедээ үлдээсэн өв сургааль 20
Гэрэл зургийн эвлүүлэг

Ном зүй 23
Нэмж унших материалууд болон вэб хуудсууд

A Quiet Woman Whose Book Spoke Loudly

By Phyllis McIntosh

shy, unassuming scientist and former civil servant, Rachel Carson seemed an unlikely candidate to become one of the most influential women in modern America. But Carson had two lifelong passions—a love of nature and a love of writing—that compelled her in 1962 to publish *Silent Spring*, the book that awakened environmental consciousness in the American public and led to an unprecedented national effort to safeguard the natural world from chemical destruction.

As a trained scientist, Carson meticulously documented her conclusions about the long-term dangers of pesticides; as a skilled writer, she communicated those dangers in language the average reader could understand.

Даруухан зохиолч эмэгтэйн даацтай бүтээлүүд

Филлис МэкИнтош

өрийн алба хашиж явсан эрдэмтэн эмэгтэй, дуу цөөтэй энгийн даруухан Рэйчель Карсоныг АНУ-ын орчин цагийн хамгийн нөлөө бүхий эмэгтэйчүүдийн нэг болно гэж хэн ч төсөөлж байсангүй. Карсон насан туршдаа дээдлэн явсан хоёр зүйл болох эх байгалиа хайрлан хамгаалах, ном зохиол бичих дур сонирхолдоо хөтлөгдөн "*Чимээгүй хавар*" номоо 1962 онд хэвлүүлжээ. Түүний энэ ном америкчуудыг ухааруулж, байгаль орчинтойгоо зөвөөр харьцах, химийн хорт бодисын учруулах сүйрлээс байгаль дэлхийгээ авран хамгаалахад уриалан дуудсанаар байгаль орчноо хамгаалах үндэсний хэмжээний хөдөлгөөнд орон даяараа анх удаа нэгдэн тэмцэж эхлэхэд хүргэсэн юм.

Нарийн мэргэшсэн эрдэмтний хувьд Карсон хортон шавьж устгах бодисын урт хугацаанд үзүүлэх үр дагаврын талаархи дүгнэлтээ сайтар баримтжуулж, чадварлаг зохиолчийн хувиар тэрхүү болзошгүй аюул заналын тухай ердийн уншигчдад ойлгоход дөхөм байхаар энгийнээр бичжээ.

A Born Naturalist

Rachel Carson was born 100 years ago in a small town in western Pennsylvania. Even though she grew up far from the seacoast, she recalled that even as a child she felt "absolute fascination for every thing related to the ocean." She also was determined that one day she would be a writer.

As a student at Pennsylvania College for Women, she majored in English until her junior year, when she switched to biology–a bold move at a time when few women entered the sciences. She went on to graduate cum laude from Johns Hopkins University with a master's degree in marine biology in 1932. While teaching zoology at the University of Maryland, Carson spent summers studying at the Woods Hole Marine Biological Laboratory in Massachusetts, where she saw her beloved sea for the first time.

She began her civil service career writing science radio scripts for the U.S. Bureau of Fisheries and in 1936 was offered a job as an aquatic biologist, only the second women ever hired by the agency in a professional position. Carson spent 5 years in the federal government writing educational materials about conservation and natural resources and editing scientific articles. By the time she

Renowned author Rachel Carson at her home near Washington, D.C, March 1963.

Нэрт зохиолч Рэйчель Карсон гэртээ байгаа нь. Вашингтон хот, 1963 оны 3-р сар.

Байгаль судлах одонд төрсөн хүн

Рэйчель Карсон, Пенсильвани муж улсын баруун хэсэгт жижигхэн хотод нэгэн зууны өмнө төржээ. Тэрээр далайгаас хол газар өсч өндийсэн ч хүүхэд байхаасаа л "далай тэнгистэй холбоотой бүх юм сэтгэлийг минь үнэнхүү их татдаг байлаа " хэмээн дурссан байдаг. Тэрээр багаасаа хэзээ нэг цагт зохиолч болно гэж шийдсэн ажээ.

Карсон Пенсильванийн Эмэгтэйчүүдийн коллежид суралцаж байхдаа гуравдугаар анги хүртэл үзэж байсан англи хэлийг биологийн ухаанаар сольж, шинжлэх ухааны талбарт хуруу дарам цөөн эмэгтэй хүч сорьж байсан тэр үед энэ нь тун зоримог алхам болсон юм. Тэрээр 1932 онд Жонс Хопкинсийн Их сургуулийг тэнгисийн биологийн магистрын зэрэгтэй онц дүнтэй төгсчээ. Мэрилэндийн их сургуульд амьтан судлалын багшаар ажиллаж байсан Карсон зуны амралтаар Массачусетс дахь Вудс Холлын Тэнгисийн биологийн лабораторид судалгаа хийх далимаар хүүхэд ахуй наснаасаа сонирхонтэмүүлдэг байсан далайг анх удаа өөрийн нүдээр очиж харсан гэдэг.

Тэрээр анх АНУ-ын Загас агнуурын товчоонд радиогийн нэвтрүүлэгт шинжлэх ухааны зохиомж бичиж төрийн алба хаших гараагаа эхэлсэн. 1936 онд Карсонд тэнгисийн биологчоор ажиллах санал тавьсан нь түүнд тус агентлагт мэргэжлийн албан тушаалд томилогдсон хоёр дахь эмэгтэй болох завшаан тохиосон юм. Ийнхүү Карсон Холбооны Засгийн газарт 15 жил тасралтгүй ажиллахдаа байгаль, түүний нөөц баялгийг хайрлан хамгаалах талаар танин мэдэхүйн чанартай нийтлэл бичиж, шинжлэх ухааны өгүүллүүдийг хянан тохилдуулж байжээ. Тэрээр АНУ-ын Загас ба Байгаль хамгаалах албанаас эрхлэн гаргадаг ном сэтгүүлүүдийн ерөнхий редактор болтол дэвшин ажиллаж байгаад 1952 онд тэтгэвэрт гарсан.

Карсон засгийн газарт ажиллахын сацуу өөрийн дуртай сэдэв болох далай тэнгисийн

Clockwise from upper left: Rachel Carson as a young girl; sits on her mother's lap, circa 1910, next to sister Marian and brother Robert; works on her studies in Woods Hole, Massachusetts; one of Carson's many drawings of plants and animals.

Дээд тал, зүүн гараас нар зөв: Рэйчель Карсон багадаа; 1910 оны үед авахуулсан зураг дээр тэр ээжийнхээ өвөр дээр сууж, эгч Мариан, ах Роберт нарын хамт байгаа нь; Массачусетсийн Вудс Холлд судалгааны ажлаа хийж буй нь; Карсоны зурдаг байсан ургамал, амьтны холбогдолтой олон зургийн нэг нь.

retired in 1952, she had risen to editor-in chief of publications for the U.S. Fish and Wildlife Service.
While with the government, Carson continued to write independently about her love of the sea. In 1941, she published her first book, *Under the Sea-Wind*, a naturalist's look at the struggle for life in the sea and along its shores. A second book, *The Sea Around Us*, which described the processes that formed the earth and the oceans, became a best-seller and won her worldwide acclaim.

The financial success of her books made it possible for Carson to retire from the government and build a cottage on the coast of Maine. Continuing her research on the sea, she once boarded a trawler and sailed to the rough waters of the Georges Banks fishing grounds off the Massachusetts coast. Her third book, *The Edge of the Sea*, a guide to marine life, was published in 1955.

Above: Carson, shown here in 1950, was already starting to be known as an author of popular books about sea life. Below: An aircraft sprays DDT to prevent ticks on these sheep in Oregon in 1948; years later Carson wrote her most famous book about the misuse of DDT.

Дээд талд: Карсон 1950 онд. Далай тэнгис дэх амьдралыг харуулсан хэд хэдэн алдартай ном бичсэн зохиолчийн хувьд олны танил болж эхлээд байсан үе байлаа. Доод талд: 1948 онд Орегон муж улсад авсан зураг дээр хонин сүргийг хачиг зэрэг хорт шавьжнаас хамгаалахаар шууд дээрээс нь ДДТ хорыг цацаж буйг харуулсан байна. Үүнээс хойш хэдэн жилийн дараа Карсон химийн бодисын зохисгүй хэрэглээний талаар хамгийн алдартай номоо бичсэн билээ.

тухай тасралтгүй бичиж байв. Түүний анхны ном болох "Тэнгисийн салхин дор" ном 1941 онд хэвлэгдэн гарсан ба уг номд далайд болон далайн эрэг дээрх амьтдын амьдралын төлөө тэмцэж буйг байгаль судлаач хүний нүдээр харж бичсэн байдаг. Карсоны хоёр дахь ном болох "Биднийг хүрээлэн буй далай тэнгис" номонд дэлхий ертөнц болон далай тэнгис анх хэрхэн үүсэн бий болсоныг тайлбарласан нь газар газрын уншигчдын талархлыг зүй ёсоор хүлээж, хамгийн гүйлгээтэй ном болсон юм.

Дээрхи хоёр номны ачаар Карсоны санхүүгийн байдал эрс сайжирсанд тэрээр төрийн албанаас чөлөөлөгдөж, Мэйн дэхь далайн эрэг газар байшин бариулж тэндээ амьдрах болжээ. Карсон далайн тухай судалгаагаа үргэлжлүүлж, нэг удаа загас агнуурын онгоц хөлөглөн Массачусетсийн эргээс нэлээд зайтай орших Жоржсын Эрэг хэмээх загас ихтэй, ширүүн урсгалтай далайн хэсэгт очсон байдаг. Карсоны гурав дахь ном нь "Тэнгисийн хаяа" нэртэйгээр 1955 онд хэвлэгдсэн бөгөөд тэнгисийн амьдралын тухай өгүүлжээ.

A Crusading Scientist

Although most of her writing focused on the sea, Carson had long been concerned about environmental damage from overuse of chemical pesticides and as early as 1945 had tried unsuccessfully to sell an article about pesticide testing to *Reader's Digest* magazine. In 1958, with evidence mounting about the hazards of DDT and other pesticides, Carson was moved by a letter she received from friends on Cape Cod, Massachusetts, describing how aerial spraying of DDT had killed numerous birds on their private land.

She resolved to alert the public to the dangers and, once again unable to sell a magazine article on the subject, set to work on *Silent Spring*. Over the next four years, she meticulously researched the book and, anticipating sharp criticism from chemical companies, compiled 55 pages of sources and an extensive list of experts who had reviewed her manuscript.

When the first installment of the book appeared in the *New Yorker* magazine in summer 1962, the chemical industry, as expected, decried her as a "hysterical woman." The book quickly found favor with the public, however, especially after a major television network aired a special about pesticides that featured an interview with a calm, reasoned Carson.

Carson testifies at a 1963 Senate hearing on pesticides, where she advocated creating a government regulatory agency for pesticides.

Карсон 1963 онд химийн хорт бодисын асуудлаар Сенатад тайлбар тавьж, химийн хорт бодис хэрэглэхийг зохицуулах засгийн газрын агентлаг байгуулахыг уриалж байна.

Тэмцэгч эрдэмтэн

Ихэвчлэн далай тэнгисийн тухай бичдэг байсан Карсон, химийн хорт бодисыг хэтрүүлэн хэрэглэснээс байгаль орчинд учрах сөрөг үр дагаврын талаар эртнээс сэтгэл нь зовниж байсан тул 1945 оны эхээр хорхой шавьж устгах хорыг туршиж байгаа тухай нийтлэл бичиж *Рийдэрз Дайжест* сэтгүүлд хэвлүүлэхээр өгсөн боловч уг сэтгүүл хүлээж авсангүй. Хортон шавьжны эсрэг ДДТ /дуст/ хэмээх үнэргүй хор болон бусад химийн бодис хэрэглэх нь аюултай болох талаар хангалттай нотлох баримт мэдээлэл гарч байсан 1958 онд Массачусетсийн Кэйп Кодод амьдардаг Карсоны найз нөхөд, агаараас хорхой шавьжны эсрэг хор цацсаны улмаас тэдгээрийн хувийн эзэмшлийн газар талбайд шувууд үй олноороо үхэх болсон тухай захидал бичсэн нь түүний сэтгэлийг ихэд эмзэглүүлжээ.

Карсон уг аюулын талаар олон нийтэд сэрэмжлүүлэх нийтлэл бичиж, өөр нэг сэтгүүлд хэвлүүлэх гэсэн боловч тэд мөн л хүлээж авсангүй. Ийнхүү тэр "*Чимээгүй хавар*" бүтээл дээрээ сэтгэл шулуудан ажиллаж эхэлсэн. Чингэхдээ дөрвөн жилийн туршид уг номд орох судалгааны баримтууд дээр уйгагүй ажиллахдаа химийн компаниуд хэл ам гаргаж эсэргүүцнэ гэдгийг урьдаас мэдэж байсан тул 55 хуудас бүхий эх сурвалж баримт бэлтгэн, гар бичмэлийг нь үзэж баталгаажуулсан нарийн мэргэжилтэн нэлээд хэдэн хүний нэрсийн жагсаалтыг гаргасан байв.

Уг номын эхний хэсэг 1962 оны зун *Нью Йоркер* сэтгүүлд хэвлэгдэн гарахад химийн үйлдвэрийнхэн, Карсоны бодож байсанчлан, түүнийг "сүржин амьтан" хэмээн гоочилжээ. Тус ном богино хугацаанд уншигчдын талархлыг хүлээсэн ба нэн ялангуяа телевизийн нэгэн томоохон суваг үг цөөтэй, учир мэдэх Карсонтой хортон, шавьжны эсрэг хэрэглэж буй хорт бодисын

In addition to TV appearances and interviews, Carson testified before several congressional committees and called for establishment of a "Pesticide Commission" or some type of regulatory agency to protect people and the environment from chemical hazards.

Lasting Legacy

Seven years later, in 1970, Congress created the Environmental Protection Agency, a direct result of the environmental movement sparked by *Silent Spring*. In 1972, the government banned DDT, the pesticide that had helped push America's national symbol, the bald eagle, and other birds to the brink of extinction.

Few people knew at the time that while Rachel Carson was writing Silent Spring and enduring the controversy that followed its publication, she was waging a losing battle against breast cancer. In April 1964, at age 56, she died at her home in Silver Spring, Maryland, just outside Washington, D.C., never knowing of the landmark legislation that resulted from her work.

"Now I can believe that I have at least helped a little," she had written modestly to a friend in 1962. "It would be unrealistic to believe one book could bring a complete change." She could not have been more wrong. As Carson biographer Linda Lear has noted: "In the face of personal attack, and in spite of being gravely ill, Rachel Carson provided a compelling example of the power of the single individual to bring about change."

тухай ярилцлага хийж нэвтрүүлсний дараа түүний бичсэн номын ач холбогдлыг олон нийт улам их ухаарах болжээ.
Телевизээр гарч, ярилцлага өгөхийн зэрэгцээ Карсон Конгрессийн хэд хэдэн хорооны хурал дээр тайлбар өгч, хүн ба байгаль орчныг химийн бодисын аюул заналаас хамгаалахын тулд "Хорхой шавьжны эсрэг химийн хорт бодис хэрэглэх явдлыг журамлах хороо" буюу өөр ямар нэг зохицуулагч агентлаг байгуулахыг уриалж байлаа.

Хойч үедээ үлдээсэн өв сургааль

"*Чимээгүй Хавар*" номын ачаар Байгаль орчныг хамгаалах хөдөлгөөн үүсэн бий болж, эрч хүчээ авсны шууд үр дүнд долоон жилийн дараа 1970 онд Конгресс Байгаль орчныг хамгаалах агентлагийг анх байгуулсан юм. Хортон шавьжны эсрэг ДДТ хорыг хэрэглэсний улмаас Америкийн үндэсний бэлэг тэмдэг болсон цагаан толгойт бүргэдийн тоо толгой үлэмж хорогдож, бусад олон шувуу устаж үгүй болохын ирмэгт тулж ирээд байсан 1972 онд Засгийн газар ДДТ/дуст/-ыг хэрэглэхийг хорих шийдвэр гаргасан юм.
Харамсалтай нь "Чимээгүй хавар" номоо бичиж байхдаа ч, мөн ном хэвлэгдэн гарсны дараа элдэв маргаан эсэргүүцлийг даван туулж байхдаа ч Рэйчель Карсон хөхний хорт хавдар тусч, өвчнийхөө эсрэг тэмцэж байсан, мөн түүний амьд явах хоног нь улам бүр цөөрч байсныг гадарлах хүн олон байсангүй. Түүний бичсэн ном нь түүхийн хуудаснаа тодоос тод тэмдэглэгдэн үлдсэн ба үнэтэй хууль тогтоомж батлагдан гарахад хүргэснийг тэрээр мэдэж амжаагүй юм, Карсон 1964 оны дөрөвдүгээр сард Вашингтон хотын ойролцоо Мэрилэндийн Силвер Спринг дахь гэртээ 56 насандаа өөд болжээ.

"Сая л нэг бага ч атугай тус нэмэр болов уу гэж бодох юм. Гэхдээ ганц номоор бүхнийг эрс өөрчлөнө гэж юу байх вэ дээ" гэж тэрээр 1962 онд нэгэн найздаа даруухнаар

Phyllis McIntosh, a former contributing editor of National Wildlife *magazine, frequently writes about health issues.*

бичиж байжээ. Харин Карсон энэ удаа том эндүүрчээ. Карсоны намтрыг бичигч Линда Лир энэ тухай бичихдээ, "Рэйчель Карсон, бусад олны дайралтын эсрэг ганцаар зогсож байхдаа ч, хүнд өвчний эсрэг цаг мөч тутам тэмцэж байхдаа ч хэрхэн нэг хүн дангаараа их өөрчлөлтийг авчрах сүр хүч, чадалтай байдгийг харуулсан амьд жишээ болсон юм" хэмээжээ.

Филис МэкИнтош, урьд нь Үндэсний Онгон Байгаль *сэтгүүлийн эрхлэгчээр ажиллаж байсан, эрүүл мэндийн асуудлаар тогтмол нийтлэл өгүүлэл бичдэг.*

Photographed in Maine a year before her 1964 death from breast cancer, Carson did not realize the extent of the movement her book started.

1964 онд хөхний хорт хавдрын улмаас нас барахаас нэг жилийн өмнө Мэйнд авахуулсан зураг. Карсон, өөрийнх нь бичсэн ном байгаль орчныг хамгаалах тэмцэл, хөдөлгөөний эхийг тавьж уг хөдөлгөөн хэр их өргөн цар хүрээтэй болж тэлэхийг төсөөлөө ч үгүй байлаа.

A Book That Changed a Nation

By Michael Jay Friedman

In 1992, a panel of notable Americans offered their choices for the single book published during the previous half century that most profoundly influenced the thoughts and actions of humankind. More panelists cited Rachel Carson's *Silent Spring* than any other title.

Silent Spring's lasting power to inspire flows less from Carson's diligent research—even before publication, critics attacked some of her findings—but rather from its elegant prose, effective presentation, and fortuitous timing. Silent Spring focused the attention of millions, in America and then throughout the world, on an idea they were increasingly prepared to consider: that the indiscriminate use of pesticides threatened profoundly both the health of mankind and that of the world in which he lived.



As Yale University historian Daniel J. Keveles has written: "Carson's book probably did more than any other single publication or event to set

A first edition of Silent Spring, now valued at $500. Its famous "Fable for Tomorrow" is excerpted on a National Park Service Web page at http://planning.nps.gov/wilderness/idea61.cfm.

"Чимээгүй хавар" номын анхны дугаар эдүгээ 500 долларaар үнэлэгдэж байна. "Маргаашийн тухай ёгт үлгэр" хэмээх алдарт хэсгээс нь Үндэсний Дархан Цаазат Газрын вэб хуудаст иш татаж, http://planning.nps.gov/wilderness/idea61.cfm-т байрлуулжээ.

Америк оронд өөрчлөлт авчирсан ном

Майкл Жэй Фрийдмэн

1992 онд Америкийн нэр нөлөө бүхий хүмүүсээс бүрдсэн зөвлөлийн гишүүд зууны өнгөрсөн хагаст хэвлэгдэн гарсан бүх номноос хүн төрөлхтний бодол, үйлдэлд хамгийн гүн гүнзгий ул мөрөө үлдээсэн нэг номыг тодруулахад олонхи нь Рэйчель Карсоны "Чимээгүй хавар"-ыг сонгосон юм.

"*Чимээгүй хавар*" номын он жилүүдийг давсан ач холбогдол нь Карсоны нөр хичээнгүйлэн хийсэн судалгааны ажилтай төдийлэн холбоогүй юм. Харин ч уг номыг хэвлэгдэн гарахаас өмнө шүүмжлэгчид түүний зарим нээлт дүгнэлтэнд эргэлзэж байлаа. Карсоны эрхэмсэг чамин найруулга, оновчтой дүрслэл, цаг үеэ олсон сэдэв зэрэг хүчин зүйл нь түүний номыг үеийн үед уншигдах ном болгосон юм. "Чимээгүй хавар" ном нь Америкаар зогсохгүй дэлхий даяар хэдэн сая хүнд хүрч, химийн хорт бодисын зохисгүй хэрэглээ хүн төрөлхтний эрүүл мэнд, хүрээлэн буй байгаль орчинд нөхөж барамгүй аюул занал учруулж болзошгүй чухал асуудалд хүн бүрийн анхаарлыг татсан билээ.

Йелийн Их сургуулийн түүхч Даниэль Жэй Кевелес, "Карсоны ном, 60-аад оны үед байгаль орчныг хамгаалах хөдөлгөөн анх бий болоход түлхэц болсноороо бусад ном зохиол, болсон үйл явдалтай харьцуулахад олон нийтийг ухааруулахад илүү их үүрэг гүйцэтгэсэн" хэмээжээ.



off the new environmental movement that emerged in the Sixties."

Only a few works have similarly catalyzed American public opinion as a force for change. Carson's impact compares with that of Thomas Paine, whose 1776 pamphlet *Common Sense* spurred popular support for American independence from Great Britain. American works of comparable influence might also include *Uncle Tom's Cabin* (1852) by Harriet Beecher Stowe, which energized the struggle against slavery, and *The Jungle* (1906) by Upton Sinclair, which described unhealthful meatpacking practices and sparked the passage of federal food inspection laws.

Toxic Connections

Rachel Carson had long suspected that increasingly powerful chemical pesticides were being used carelessly, and she feared their impact on the environment. In 1958, Carson's friends Stuart and Olga Huckins propelled her investigations. The Huckinses owned a twoacre bird sanctuary near Duxbury, Massachusetts. After the government doused it with pesticides as part of a mosquito eradication program, many native songbirds perished, their nesting places, ponds, and birdbaths contaminated.

For the next four years, Carson consulted with scientific experts. "The more I learned about the use of pesticides, the more appalled I became," she later said. "I realized that here was the material for a book.

What I discovered was that everything which meant most to me as a naturalist was being threatened, and that nothing I could do would be more important."

Америкийн түүхэнд олон нийтийн санаа бодлыг өөрчлөлт шинэчлэлд тууштай чиглүүлж чадсан цөөн тооны бүтээл байдаг. Карсоны ном ард түмэндээ үзүүлсэн үр нөлөөгөөрөө, Их Британиас хараат байсан Америкийг тусгаар тогтнолоо тогтооход ард олны дэмжлэгийг өрнүүлсэн Томас Пэйний 1776 онд бичсэн "*Эрцүл ухаан*" бүтээлтэй эн зэрэгцдэг юм. Мөн энэ хэмжээнд түүхэнд мөнхөрсөн бусад бүтээлээс дурдвал боолчлолын ёсыг эсэргүүцэн тэмцэхэд хүргэсэн Харриет Бийчэр Стөүийн "*Авга ах Томын бүхээг*" (1852), мөн махыг савлаж байсан арга нь хүний эрүүл мэндэд харш болохыг харуулснаар холбооны улсын хүнсний аюулгүй байдлыг шалгах хууль тогтоомжийг батлахад хүргэсэн Аптон Синклэйрийн бичсэн "*Ширэнгэн Ой*" (1906) бүтээлүүдийг тус тус дурдаж болно.

Химийн бодисын хорт үр дагавар

Рэйчель Карсон, хортон шавьжны эсрэг хэрэглэх хорыг улам их хүчтэй химийн бодисоор орлуулж гэнэн байдлаар хэрэглэж байгааг эртнээс гадарлан, эдгээрийн байгаль орчинд учруулах хор уршгаас эмээж байсан. Карсоны дотны нөхөд болох Стюарт ба Ольга Хаккинс нар түүнийг судалгаагаа улам лавшруулахад хүргэжээ. Хаккинсийн гэр бүл Массачусетсийн Даксбурид шувууны тусгай хамгаалалтын найм гаруй мянган ам метр эдлэнтэй ажээ. Засгийн газраас эхлүүлсэн Шумуул устгах хөтөлбөрийн хүрээнд тэр газарт нь хорхой шавьж устгах хор цацсаны дараагаар байгалийн олон дууч шувууд үхэж үрэгдэн, тэдний үүрлэдэг байсан газар, усны шувуудын амьдардаг намаг цөөрөм зэрэг нь цөм хоронд автагдсан байв.

Карсон эл явдлаас хойш дөрвөн жилийн туршид эрдэмтэд, мэргэжлийн хүмүүстэй уулзаж санал бодлоо уйгагүй солилцсон байдаг. "Химийн хорын талаар илүү ихийг олж мэдэхийн хирээр айж цочирдох минь нэмэгдсээр байлаа. Бодоод байсан чинь нэг ном болох хэмжээний материал цугларчихсан байв. Байгаль судлаачийн хувьд надад хамгаас нандин зүйл бүхэнд аюул занал нүүрлээд байгаа нь тодорхой байсан учир үүнийгээ аврахын төлөө миний

Carson concluded that in a natural environment of interconnected species, chemicals aimed only at insects or other pests were soon ingested by other organisms and passed up the food chain. After the city of Detroit sprayed insecticide on local elm trees, Carson observed, it subsequently collected the dead bodies of DDT-contaminated robins. The birds had feasted on earthworms that had in turn ingested fallen leaves from the sprayed trees.

"As few as 11 large earthworms can transfer a lethal dose of DDT to a robin," Carson wrote. "And worms form a small part of a day's rations to a bird that eats 10 to 12 earthworms in as many minutes."

About half of Carson's manuscript appeared in June 1962 over three consecutive issues of the New Yorker magazine. The excerpts ignited a national controversy. The U.S. Department of Agriculture received many letters expressing "horror and amazement" that DDT and other chemical "elixirs of death" were in common use.
Asked whether the U.S. government was investigating the use of DDT, President John F. Kennedy replied, "Yes ... particularly since Miss Carson's book."

Much of the chemical industry saw *Silent Spring* as a threat. "Our members are raising hell," one pesticide trade association divulged. The *New York Times* reported that "some chemical concerns have set their scientists to analyze Miss Carson's work line by line."

But critics could find little factual error. Criticism focused instead on how Carson dramatized her concerns and minimized the real benefits of pesticides in assuring plentiful, affordable food supplies. "She tries to scare the living daylights out of us," wrote the *New York Times* book reviewer of *Silent Spring*, "and, in large measure, succeeds."

хийх өчүүхэн ч юм багадахгүй гэдгийг би тэгэхэд ойлгосон" гэж тэрээр нэгэнтээ хэлсэн байдаг.

Рэйчель Карсон ямар дүгнэлтэнд хүрсэн бэ гэвэл, нэгэнт байгалийн амьтны төрөл зүйлс өөр хоорондоо байнгын харилцаа холбоотой байдаг учраас хорхой шавьж, хортон мэрэгчдийг устгах химийн хорыг өөр бусад бие организм ч залгиж, улмаар тэр нь хоол боловсруулах эрхтнээр дамжин биед нь шингэдэг. Детройт хотынхон ойр орчмынхоо хайлаас модонд шавьжны хор цацсаны улмаас ДДТ хоронд хордож үхсэн улаан гүеэт гургалдайг олноор түүж хаяж байсныг Карсон олж харжээ. Эдгээр шувууд, хор цацсан моддоос унасан дэл сул навчаар хооллосон чийгийн улаан хорхой идсэн тул хордож үхчээ.

"Улаан гүеэт гургалдай чийгийн хорхойны томоос нь арван нэгийг идэхэд л үхэлд хүргэх хэмжээний хорыг өөртөө шингээлээ гэсэн үг. 10-12 минутад өдий тооны чийгийн хорхойгоор хооллодог шувууны хувьд 11 чийгийн хорхой гэдэг бол нэг өдрийнх нь хүнсний өчүүхэн хувийг эзэлнэ" гэж Карсон бичиж байсан.
Нью Йоркер сэтгүүл 1962 оны 6-р сард гурван дугаартаа дараалан Карсоны гар бичмэлийн бараг тэн хагасыг хэвлэн гаргасан нь улс үндэсний хэмжээнд ихээхэн шуугиан дэгдээсэн юм. АНУ-ын Хөдөө аж ахуйн яаманд химийн хорт бодис болон бас бус "үхлийн тун бүхий" бодисыг өргөнөөр хэрэглэж байгаад "айн цочирдож, бас гайхшаа барж буйгаа" илэрхийлсэн олон зуун захидал ирсээр байжээ.

Ерөнхийлөгч Жон Ф.Кеннедигээс АНУ-ын Засгийн газар ДДТ хорын хэрэглээг шалгаж байгаа эсэх тухай асуухад тэрээр "Тийм ээ, ялангуяа хатагтай Карсоны номыг уншсанаас хойш бүр ч их .." хэмээн хариулсан байдаг.

Химийн ихэнх компаний хувьд "*Чимээгүй хавар*" ном түгшүүрийн харанга дэлдэж байв. "Манай гишүүд хамаг муу үгээ барж байна" хэмээн химийн бодисын борлуулалтын нэгэн нийгэмлэгийнхэн ам алджээ. "Химийн хорт бодистой холбоотой

The publicity stoked public demand for the book. *Silent Spring* was published in complete book form in September 1962, chosen as the Book-of-the-Month Club's October selection, and quickly emerged as a runaway bestseller. The CBS television network broadcast an hour-long documentary about the book.

This wetland marsh is part of the Rachel Carson National Wildlife Refuge, which comprises 10 parcels of land scattered across about 80 kilometers of Atlantic coastline near Carson's summer home in Maine.

Зураг дээрхи намгархуу газар нь Рэйчель Карсоны Үндэсний Онгон Байдлын Хүрээлэнгийн нэг хэсэг юм. Тус газар Мэйн муж улс дахь Карсоны зуслангийн байшингийн ойролцоо Атлантын далайн эрэг дагуу 80 км газар сунан байрласан 10 хэсэг газраас бүрддэг.

асуудлаас үүдэн тэдгээр компаниуд эрдэмтдээ хатагтай Карсоны бүтээлийг мөр алгасахгүй судлахыг үүрэг болгоод байна" гэж *Нью Йорк Таймс* мэдээлж байлаа.

Гэхдээ Карсоны гаргасан баримт нотолгоонд яг тэр гэхээр алдаа олж чадахгүй байсан тул түүнийг асуудлыг хэт дэвэргэн сүржигнэсэн, хүнсний элбэг дэлбэг, хямд төсөр ханган нийлүүлтэд химийн бодис хэрэглэх нь ач тустай байгааг үл ойшоосон хэмээн шүүмжилж бичих нь олон байв. "Тэр биднийг айлгаж цочоохыг санаархаж байна, тэгээд ч тэр хэмжээгээрээ санасандаа хүрч чадаж байна" гэж *Нью Йорк Таймс* сонины ном зохиолын шүүмжлэгч бичсэн байдаг.

Дээрхи шүүмжлэл маргаан нь олон нийтийн дунд уг номыг авч унших хүслийг улам нэмэгдүүлжээ. "*Чимээгүй хавар*" нь 1962 оны 9-р сард иж бүрэн ном болон хэвлэлээс гарч, "Сарын шилдэг ном" клубын 10-р сарын шилдэг номоор шалгарч, удалгүй хамгийн гүйлгээтэй номоор тодорчээ. СиБиЭс телевизийн суваг уг номын талаар нэг цагийн баримтат кино бэлдэж гаргасан байдаг.

A Larger Truth

As Carson's critics understood, Silent Spring possessed an emotional power that overcame objections to specific bits of Carson's argument. Even as Time magazine argued that "many of the scary generalizations ... are patently unsound," most readers concluded that Carson understood and depicted accurately a larger truth: that mankind's growing reliance on deadly chemicals carried real and not fully understood costs.

Few readers could resist Carson's literary skill. "There was once a town in the heart of America where all life seemed to live in harmony with its surroundings," she wrote:

Then a strange blight crept over the area and everything began to change. ... There was a strange stillness. ... The few birds seen anywhere were moribund; they trembled violently and could not fly. It was a spring without voices. On the mornings that had once throbbed with the dawn chorus of scores of bird voices there was now no sound; only silence lay over the fields and woods and marsh.

In May 1963, President Kennedy's Science Advisory Committee released a 43-page report that called for limits on the use of pesticides. Kennedy immediately ordered implementation of its recommendations, which included an end to some Department of Agriculture spraying programs and a Food and Drug Administration (FDA) review — "as rapidly as possible" — of tolerance levels for pesticide residue in the food supply. The report also acknowledged that "until publication of S*ilent Spring* by Rachel Carson, people were generally unaware of the toxicity of pesticides."

Бодит үнэн

Карсоны номондоо дэлгэж тавьсан зарим нэг тоо баримт шүүмжлэлд өртсөн хэдий ч "*Чимээгүй хавар*" номын эгэл хүний сэтгэлд хүрэх өвөрмөц хүч чадал нь давуу байсныг шүүмжилж байсан хүмүүс хүлээн зөвшөөрсөн юм. Тайм сэтгүүл хүртэл "түгшүүр төрүүлсэн баримт нотолгооны дийлэнх нь ... илт төөрөлдсөн байна" хэмээн шүүмжлэнгүй бичиж байсан удаатай. Харин уншигчид, үхлийн аюул тээсэн химийн хорыг өргөнөөр хэрэглэж хэвших нь алсдаа урд өмнө огт төсөөлж байгаагүй их алдагдал, гамшигт хүн төрөлхтнийг хүргэх аюул тээж буйг Карсон олон түмэнд сонордуулахыг зорьсоныг зөвөөр ойлгож, түүнийг уг санаагаа эмх цэгцтэй илэрхийлсэн хэмээн үзжээ.

Карсоны ном бичих ур чадварыг уншигчид өндрөөр үнэлсэн юм. Тэрээр ийнхүү өгүүлсэн байдаг: "Америк орны төв хэсэгт нэгэн хот оршдог байжээ. Хот тэр аяараа орчин тойронтойгоо зохицолдон эвтэй найртай амьдралаар дүүрэн байлаа..."гээд цааш нь үргэлжлүүлэхдээ:

"Тэгтэл өмнө байгаагүй нэгэн тахал мэт хар юм хаа сайгүй чимээгүйхэн гэтэж тархахын хирээр бүх юм урьдын мөн чанараа алдаж хувьсаж эхлэв. ... Амьдрал зогссон мэт нэг л ер бусын чимээ аниргүй. ... Хаа нэгтээ харагдах ганц хоёр шувуу үхэл ирж явааг мэдэрсэн юм шиг бөмбөгөнөтөл чичирч жигүүрээ дэлгэн нисэж үл чадан бээрсэн бололтой. Үүрийн гэгээг шувуудын жиргээнээр тосон угтдаг байсан энэ газар энэ удаа дуу чимээгүй хавар ирж, тариалангийн талбай, ой мод, ус намаг эл хуль болж, чимээ анир тасрав..." гэсэн байв.

1963 оны 5-р сард ерөнхийлөгч Кеннедигийн дэргэд ажиллаж байсан Шинжлэх ухааны зөвлөх хорооноос хортон шавьжны эсрэг хэрэглэх химийн хорыг хязгаарлахыг уриалсан 43 хуудас илтгэл гаргасан. Ерөнхийлөгч Кеннеди тус илтгэлд дэвшүүлсэн санаачлагыг хэрэгжүүлэх тухай тушаал батласан. Уг тушаалын дагуу Хөдөө аж ахуйн яамнаас авч хэрэгжүүлдэг химийн бодис цацах зарим хөтөлбөрийг зогсоох болж, хүнсний хангамжид хорт бодисын үлдцийн хэмжээ тунг "үтэр түргэн"

Silent Spring proved a hugely significant catalyst for measures protecting the natural environment in the United States and beyond. In 1972, the FDA banned nearly all uses of DDT in the United States (many believe that, properly used, the chemical affords benefits in malaria-plagued nations), and new laws limited commercial pesticide use to properly trained "certified applicators."

Rachel Carson lived only one and a half years beyond *Silent Spring's* publication, not long enough to witness its full contribution to the rebirth of environmental consciousness, but enough to know she had made a difference. "I have felt bound by a solemn obligation to do what I could," she wrote a friend. "But now I can believe that I have at least helped a little."

Michael Jay Friedman is a staff writer with the U.S. State Department's Bureau of International Information Programs.



тогтоохыг Хүнс ба эмийн асуудал хариуцсан захиргаанд даалгажээ. Түүнчлэн тус илтгэлд "Рэйчель Карсоны бичсэн "*Чимээгүй хавар*" номыг хэвлэгдэн гарах хүртэл химийн бодисын хор уршгын талаарх хүмүүсийн мэдлэг ерөнхийдөө тун бага байсан" хэмээн дурдсан байдаг.

"*Чимээгүй хавар*" ном АНУ болон дэлхийн бусад улс оронд байгаль орчноо хамгаалах арга хэмжээг эрчимжүүлэхэд үлэмж үүрэг гүйцэтгэсэн. Хүнс ба эмийн асуудал хариуцсан захиргааны газраас 1972 онд АНУ-д ДДТ химийн хорт бодисыг хэрэглэхийг хориглож, (хумхаа өвчин элбэг байдаг зарим улс оронд тус химийн бодисын зохистой хэрэглээ ач тусаа өгдөг гэж үзэх хүн цөөнгүй байдаг), шинээр батлагдсан хуулийн дагуу хортон шавьж устгах дээрх хорыг тусгайлан бэлтгэгдсэн мэргэжлийн хүмүүсээр цацуулж хэрэглүүлж байхаар хязгаар тогтоожээ.

"*Чимээгүй хавар*" ном нь хэвлэгдэн гарч, төдөлгүй жил хагасын дараа Рэйчель Карсон нас барахдаа байгаль орчноо хамгаалах үйлсэд түмэн олныг сэрээж ухааруулахад түүний ном хичнээн их үүрэг гүйцэтгэснийг мэдэж амжаагүй ч энэ бүхний төлөө чадлынхаа хирээр зүтгэсэн гэдгээ мэдэж байсан. "Би чадах бүхнээ хийх үүрэгтэй гэдгээ цаг ямагт ухамсарладаг байсан. Харин одоо бага ч болов нэмэр болсон байх гэж итгэж байна" хэмээн найздаа бичиж байжээ.

Майкл Жэй Фрийдмэн нь АНУ-ын Төрийн Департаментын Олон Улсын Мэдээллийн Хөтөлбөр хариуцсан Товчооны орон тооны зохиолч юм.



A Persistent Controversy, a Still Valid Warning

By May Berenbaum

Probably few people today remember the best-selling nonfiction book of 1962 despite the scandal that surrounded it. The book, a diet guide titled *Calories Don't Count*, sold more than two million copies. Its author, Herman Taller, was spectacularly convicted of mail fraud, drug violations, and conspiracy charges five years later over unsubstantiated claims regarding the efficacy of safflower-oil capsules in mitigating the effects of unfettered carbohydrate-free calorie intake.

Although it didn't sell nearly as well, another nonfiction book published that year has had a much more lasting impact; its title, *Silent Spring*, is recognizable today, and its author, already in 1962 a best-selling popular science writer, remains a household name 43 years after her death. Among the book's legacies are heightened public concern about the environmental consequences of pesticide abuse, including strengthened opposition to one pesticide in particular, the chlorinated hydrocarbon DDT, and more broadly a revitalized and empowered environmental movement.

Бэрх сорилтыг давж чадсан сэрэмжлүүлэг

Мэй Беренбаум

1962 онд шинээр гарах үедээ нэлээдгүй дуулиан дэгдээсэн ч уншигчдыг олноор нь байлдан дагуулж байсан нэгэн номыг өнөөдөр санах хүн бараг үгүй биз ээ. "*Илчлэгийг хэмжиж болдоггүй*" хэмээх нэртэй хоолны дэглэм барих заавар бүхий зохиолын бус уг ном хоёр саяас дээш хувиар борлогдсон. Уг номыг зохиогч Херман Толлер 5 жилийн дараа хэд хэдэн хэрэгт буруутгагдсан нь шуудангийн хуйвалдаанд оролцсон, хар тамхи хэрэглэсэн, мөн нүүрс усгүй илчлэгтэй хүнс хэрэглэсний үр нөлөөг наранцэцгийн тосны капсул хэрэглэх замаар нөхөх талаар нотлогдоогүй мэдэгдэл гаргасан зэрэг байлаа.

Тус онд хэвлэгдэн гарсан бас нэг баримтат ном борлуулалтаараа дээрхи номд хүрээгүй ч үр нөлөөгөөрөө зүйрлэхийн аргагүй урт настай болсон нь "*Чимээгүй хавар*" юм. Уг номыг бичсэн Рэйчель Карсон 1962 онд борлуулалтаараа тэргүүлсэн номын эрдэмтэн зохиолч болж, түүнийг нас барснаас хойш 43 жилийн туршид алдар нэр нь түгсэн хэвээр байна. Түүний энэ ном нь химийн хорт бодисыг зүй бусаар ашиглах нь байгаль орчинд ямар их хор хөнөөлтэй болохыг олон нийтэд сэрэмжлүүлэхээс гадна нэн ялангуяа хлоржуулсан нүүрс ус болох ДДТ хэмээх химийн хорыг нэр заан онцолж, уг бодисыг хэрэглэхийг зогсоохыг уриалж, байгаль орчноо хамгаалах хөдөлгөөнийг ахин шинээр, илүү эрч хүчтэйгээр төрүүлсэн юм.

The book's core message—that over-reliance on a particular pest-control strategy could have adverse environmental effects—was hardly novel. Indeed, it was well documented in the entomological journals of the time. But Carson, an inspired and gifted writer, explained this idea in terms the general public could comprehend and, more importantly, feel. Spraying to eliminate insects or other target species, she explained, also kills birds and other nontarget organisms, even as the target species evolves resistance to the chemicals. Although aimed at a crop pest, a pesticide can inadvertently contaminate earthworms, which in turn if eaten in sufficient quantity can kill robins. Without birdsong, a silent spring ensues.

The public took her words to heart. Less than a year after *Silent Spring* first appeared serialized in the New Yorker magazine, more than 40 bills aimed at controlling use of DDT and other synthetic organic insecticides had been introduced in state legislatures across the United States. In 1972, eight years after Carson's death, the newly established Environmental Protection Agency banned the domestic use of DDT.

